



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ӨЛЗИЙТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 23

Улаан-Уул

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “а”, 25 дугаар зүйлийн 25.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 40 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах журам”-ын 1.3, 3.1, 6.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь;

1.Сумын ИТХ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 4 нэр 2834586 төгрөгийн өртөг бүхий 9 ширхэг хөрөнгийг хавсралтаар сумын Засаг даргын Тамгын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Тухайн байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг сумын Засаг дарга /Д.Цэдэнсодном/-д даалгасугай.


3.Хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэхийг төсөвт байгууллагын нягтлан бодогч нарт үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтийг 2019 оны 05 дугаар сард багтаан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн ажлын албанд ирүүлэхийг төсөвт байгууллагын даргад үүрэг болгосугай.


5.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Д.Нарантуяа/-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ГОНГОР

Ёсчилсон 2019 оны 05 сарын 21-ны өдөр



Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын  
Тэргүүлэгчдийн 2019 оны 05 дугаар сарын 21-ний  
өдрийн 23 дугаар тогтоолын хавсралт



### БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн код	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ	Тайлбар
А	1	2	3	4	5	6	7
1	00000019	Ширээ	2015.05.11	1	843600	843600	
2	00000197	Сандал	2012.12.19	4	93000	372000	
3	00000199	Эргэдэг сандал	2012.12.19	1	100000	100000	
4		Дата дугаарын төлбөр	2019.03.29	1	77000	77000	
5		Printer төхөөрөмж	2019.03.29	1	780000	780000	
6		Samsung X cover гар утас	2019.03.29	1	661986	661986	
<b>Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн дүн</b>				<b>9</b>	<b>2555586</b>	<b>2834586</b>	